



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 27

№ 01/72 ДЧА-2018/29/СТА - ТЧЗ Мандалговь хот

Г

Т

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Говь-Угтаал сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **2,081,057.00** /хоёр сая наян нэгэн мянга тавин долоон/ төгрөгийн дараах зөрчил илрэлээ.

1. Үнэт цаас, үзвэр үйлчилгээний 2,046,100.00 төгрөгийн орлогыг хүлээн авч дансанд тушаахдаа анхан шатны баримт хөтлөөгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй зөрчил илрэлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хотлох, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.7-д /Анхан шатны баримтын бурдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.3-т /Журмын 2.2-т зааснаас бусад зардлаас зайлшигүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгажс ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн шаардлагатай гээж үзвэл бэлнээр олгож болно/, 3.10-д /Монгон кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого зарлагын баримтыг бичэ/

2. Ажил олгогчоос төлөх 34,957.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг үндсэн цалингийн зардлаас зарцуулсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ын /Үндсэн цалин-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана/ гэж заасныг тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд торийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн

төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтөлөөгүй/. 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт хөтөлж, тайланг тухай бүр гаргах;
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Говь-Угтаал сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч М.Ганбуд, нягтлан бодогч Д.Мөнхдорж нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ



<sup>1</sup>Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэсгүй тохиолдолд зорчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/